



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/184

Сүхбаатар сум

Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан
хаалгах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 31 дүгээр зүйлийн 31.2, 31.6 дахь заалт, Улсын Их Хурлын 2009 оны болзол батлах тухай 33 тоот тогтоол, Засгийн газрын 2019 оны мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 85 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.2019 оны цэргийн бүртгэлээр цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 1993 оны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгуулсугай.

2.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн нэрийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн цэргийн жинхэнэ албаны татлагад хамрагдаагүй болон алба хаагаагүй шалтгаан, хуулиар чөлөөлөгдөж байсан үндэслэлүүдийг тодотгон мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоон хүн нэг бүрд мэдэгдэх хуудас хүргүүлж, төлбөрөө барагдуулсан иргэдийн цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийж баталгаажуулахыг, аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /дэд хурандаа Б.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/ нарт даалгасугай.

4.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдын мэдээг 2019 оны 05 дугаар сарын 24, 12 дугаар сарын 09-ний дотор гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлж, дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах эцсийн хугацааг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөр тогтоож, төлбөрийг заасан хугацаанд гаргуулан аймгийн Төрийн сангийн дүйцүүлэх албаны 100130000983 тоот дансанд байршуулах, төлбөрийн тайлан мэдээг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ирүүлэхийг сумдын Засаг дарга, Төрийн сангийн албаны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

My Doc Zahiramj